



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/93/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Улиастай сум  
2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [bat-undraa@audit.gov.mn](mailto:bat-undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [boldbaatarkh@audit.gov.mn](mailto:boldbaatarkh@audit.gov.mn)

Аудитор: Б.Мөнхнасан

Утас: 90066888

Цахим хаяг: [munkhnasanb@audit.gov.mn](mailto:munkhnasanb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу:

24

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



# 1.ХАРААТ АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Уластай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ТҮДЭВТЭЙ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Ц.ОТГОНБАЯР-Д

2024.03.26 № 262

талай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны санхүүжилтийг өмнөх онтой харьцуулахад 229,729.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь татвар болон татварын бус орлого 115,917.7 мянган төгрөгөөр буурсан байна. Тус онд цалин нэмэгдсэнтэй холбогдуулан орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 516,467.5 мянган төгрөгөөр, татварын орлогын санхүүжилт 251,735.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн болон улсын төсөвт байгууллагын тогтмол зардал өссөн зэрэгтэй холбоотой байна.

### Аудитын гол асуудал

Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 780,0 мянган төгрөгийн, Засаг даргын тамгын газарт 20,350.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

03.26.2024



### **Бусад асуудлын хэсэг**

Түдэвтэй сумын Засаг дарга нь тайлант онд татварын орлогыг 278,814.2 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл нь 296,043.6 мянган төгрөг буюу 5,8 хувиар давсан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

  
Д.БАТ-УНДРАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/


Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	437,004.8	517,223.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	258,600.3	251,116.2
33	АВЛАГА	146,077.5	191,411.0
35	БАРАА МАТЕРИАЛ	32,326.9	74,695.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,962,607.2	2,041,296.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,962,607.2	2,041,296.8
39200	Биет хөрөнгө	1,960,223.8	2,035,345.9
39300	Биет бус хөрөнгө	2,383.3	5,950.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,399,611.9	2,558,520.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,832.4	6,057.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,832.4	6,057.1
41300	Өглөг	6,832.4	6,057.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,392,779.6	2,552,462.9
51	Засгийн газрын хувь оролцоо	2,392,779.6	2,552,462.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	509,631.2	509,631.2
51200	Хуримтлагдсан үр дүн	1,772,654.3	1,932,337.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	110,494.1	110,494.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,399,611.9	2,558,520.0

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,969,217.6	1,611,842.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	367,653.0	251,735.3
110	Орлогын албан татвар	132,660.9	186,520.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	151,895.8	210,991.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,416.1	-24,471.6
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	1,181.3	0.0
113	Хөрөнгийн албан татвар	64,304.3	34,698.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	170,687.9	30,516.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	470,153.5	181,042.2
120	Нийтлэг татварын бус орлого	470,153.5	181,042.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,131,411.1	1,179,064.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,520,483.4	1,231,690.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,520,483.4	1,231,690.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	675,727.7	1,061,988.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,898.0	466,907.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,400.4	60,287.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,020.5	27,881.7
2104	Хангамж, бараа материалын зардал	102,153.0	34,761.2
2105	Нормативт зардал	76.0	29.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,066.6	1,305.2
2107	Томилолт, зочны зардал	4,206.1	5,638.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,525.4	8,674.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,381.7	456,503.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	844,755.7	169,702.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	448,734.2	380,152.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,065,644.9	220,468.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,616,910.7	159,683.3



## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/


Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,042,249.0	5,042,249.0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,392,779.6	2,392,779.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,009,690.3	5,009,690.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-32,558.7	-32,558.7
9	Тайлант үеийн үр дүн	-2,616,910.7	-2,616,910.7
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,392,779.6	2,392,779.6
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,552,462.9	2,552,462.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,392,779.6	2,392,779.6
19	Тайлант үеийн үр дүн	159,683.3	159,683.3

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,566,817.3	1,510,852.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	367,653.0	251,735.3
110	Орлогын албан татвар	132,660.9	186,520.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	151,895.8	210,991.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,416.1	-24,471.6
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	1,181.3	0.0
113	Хөрөнгийн албан татвар	64,304.3	34,698.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	170,687.9	30,516.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,659.3	5,694.0
1181	Газрын төлбөр	2,173.8	19,698.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	162,854.8	5,124.4
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,643.2	78,737.3
120	Нийтлэг татварын бус орлого	66,643.2	78,737.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,132,521.1	1,180,379.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,438,707.5	1,152,018.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,438,707.5	1,152,018.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	593,313.0	982,316.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,375.4	466,907.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,774.1	60,287.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,188.1	29,627.2
2104	Хангамж, бараа материалын зардал	28,706.3	24,572.4
2105	Нормативт зардал	76.0	139.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,066.2	1,476.8
2107	Томилолт, зочны зардал	4,206.1	5,638.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	66,720.1	12,971.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,200.7	380,697.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	845,394.5	169,702.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	128,109.8	358,833.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	346,699.7	245,488.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	346,699.7	245,488.8
2200	Дотоод эх үүсвэрээр	346,699.7	245,488.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-346,699.7	-245,488.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-83,000.0	-120,829.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР	83,000.0	120,829.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-301,589.9	-7,484.1




101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	560,190.2	258,600.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	258,600.3	251,116.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,637,890.6</b>	<b>1,449,689.1</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,149,598.3</b>	<b>1,108,461.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,015,763.5</b>	<b>974,626.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>483,680.6</b>	<b>466,907.8</b>
210101	Үндсэн цалин	353,553.5	320,619.2
210102	Нэмэгдэл	118,500.4	132,917.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,105.4	1,563.2
210104	Урамшуулал	9,521.3	11,807.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,460.1</b>	<b>60,287.6</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,112.8	40,995.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,836.8	4,822.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,869.5	3,858.4
210204	Ажилгүйдлийн даатгал	967.4	964.6
210205	Эрүүл мэндийн даатгал	9,673.6	9,646.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>302,208.6</b>	<b>297,255.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	30,857.4	19,699.9
210302	Түлш, халаалт	269,076.5	277,545.6
210303	Цэвэр, бохир ус	2,274.7	9.5
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,018.5</b>	<b>24,018.0</b>
210401	Бичиг хэрэг	3,570.2	3,569.7
210402	Тээвэр, шатахуун	16,334.4	16,334.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,113.9	4,113.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>139.0</b>	<b>139.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	139.0	139.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,814.4</b>	<b>10,800.2</b>
210604	Урсгал засвар	10,814.4	10,800.2
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,806.6</b>	<b>4,800.1</b>
210702	Дотоод албан томилолт	4,806.6	4,800.1
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>20,312.8</b>	<b>12,971.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,200.0	11,724.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	860.0	150.0
210803	Даатгалын үйлчилгээ	519.6	519.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255.0	253.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120.8	120.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.4	203.4
210807	Газрын төлбөр	138.3	0.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.7	0.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>109,322.9</b>	<b>97,447.7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,519.5	96,769.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	803.4	678.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>133,834.8</b>	<b>133,834.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>133,834.8</b>	<b>133,834.8</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	133,834.8	133,834.8
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>356,292.3</b>	<b>220,398.8</b>
223001	Бусад хөрөнгө	356,292.3	220,398.8
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>132,000.0</b>	<b>120,829.0</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	132,000.0	120,829.0



III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,637,890.6</b>	<b>1,538,231.1</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,389,690.6</b>	<b>1,463,628.6</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,093,398.3	1,167,336.3
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	296,292.3	296,292.3
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>248,200.0</b>	<b>74,602.5</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500.0	74,602.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	244,700.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	85,568.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	174,180.7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>32,468.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32,468.3</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>32,465.6</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	554.4
210402	Тээвэр, шатахуун	554.4
2107	Томилолт, зочны зардал	838.0
210702	Дотоод албан томилолт	838.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,073.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,073.2
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2.7</b>
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2.7</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2.7
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>32,468.3</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>32,468.3</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,468.3

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Түдэвтэй сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

**Эрхэм зорилго:** Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд оршино.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 134 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 88.1 хувьтай байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Түдэвтэй сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.



Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 158,908.1 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	258,600.3	251,116.2	(7,484.1)
Авлага	146,077.5	191,411.0	45,333.5
Бараа материал	32,326.9	74,695.9	42,369.0
Үндсэн хөрөнгө	1,962,607.2	2,041,296.8	78,689.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,399,611.9</b>	<b>2,558,520.0</b>	<b>158,908.1</b>
Өр төлбөр	6,832.4	6,057.1	(775.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,392,779.6	2,552,462.9	159,683.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,399,611.9</b>	<b>2,558,520.0</b>	<b>158,908.1</b>


#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 251,116.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,484.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Төгрөг</b>			
Төрийн сангийн харилцах	258,600.3	251,116.2	(7,484.1)
<b>Дүн</b>	<b>258,600.3</b>	<b>251,116.2</b>	<b>(7,484.1)</b>

Эх сурвалж: Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 7,484.1 мянган төгрөгөөр буурсан нь Орон нутгийн ерөнхий орлого, ХХС-ийн үлдэгдэл буурч, ОНХС-ийн төлөвлөсөн ажлууд бүрэн хийгдээгүйгээс үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 21,130.6 мянган төгрөгийн зөрчил байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 191,411.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 45,333.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	10.0	10.0	0.0
Хувь хүмүүсээс авах авлага	146,067.5	191,401.0	45,333.5
<b>Дүн</b>	<b>146,077.5</b>	<b>191,411.0</b>	<b>45,333.5</b>

Эх сурвалж: Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оны үлдэгдлээс 45,333.5 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын Тамгын газрын хувь хүмүүсээс авах авлага 1,315.0 төгрөгөөр буурсан, Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага 46,648.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Авлагатай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 74,695.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 42,369.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	-	-	-
<b>Хангамжийн материал</b>	<b>32,326.9</b>	<b>65,595.9</b>	<b>33,269.0</b>
Бичиг хэргийн материал	1,789.0	1,968.7	179.7
Аж ахуйн материал	11,146.1	41,140.2	29,994.1
Түлш, шатах тослох материал	0.0	810.2	810.2
Бусад хангамжийн материал	19,391.9	21,676.9	2,285.0
Мал амьтад	0.0	9,100.0	9,100.0
<b>Дүн</b>	<b>32,326.9</b>	<b>74,695.9</b>	<b>42,369.0</b>

Эх сурвалж: Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 42,369.0 мянган төгрөгөөр өссөн нь 17,286.5 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, данс бүртгэлд тусгасан, 661.0 мянган төгрөгийн бараа материал акталсан, тайлант онд 98,355.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 72,611.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.


Аудитын илрүүлэлт: Бараа материалтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,041,296.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 78,689.7 мянган төгрөгөөр өссөн байна.



Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>1,960,223.8</b>	<b>2,035,345.9</b>	<b>75,122.1</b>
Барилга, байгууламж, орон сууц	1,637,321.9	1,646,372.4	9,050.5
Авто-тээврийн хэрэгсэл	288,710.8	378,410.8	89,700.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	100,555.9	111,935.9	11,380.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	36,587.2	47,477.2	10,890.0
Бусад үндсэн хөрөнгө	312,855.4	370,724.8	57,869.4
Ном	1,559.7	1,559.7	0.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,383.3</b>	<b>5,950.9</b>	<b>3,567.6</b>
Программ хангамж	6,494.5	10,994.5	4,500.0
Бусад биет бус хөрөнгө	-	-	-
Хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	-421,478.2	-526,178.4	-104,700.2
<b>Дүн</b>	<b>1,962,607.2</b>	<b>2,041,296.8</b>	<b>78,689.7</b>

Эх сурвалж: Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 78,689.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 25,090.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, 154,743.7 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө, хандиваар 3,556.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй нэмэгдсэн, тайлант оны элэгдлийн зардалд 104,700.2 мянган төгрөгийг тооцож, бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь тайлант онд худалдаж авсан 4,500.0 мянган төгрөгийн программыг данс бүртгэлд зөв ангилж бүртгээгүй алдааг залруулсан байна.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 6,057.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 775.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,832.4	6,057.1	(775.3)
<b>Дүн</b>	<b>6,832.4</b>	<b>6,057.1</b>	<b>(775.3)</b>

Өр төлбөр өмнөх оны үлдэгдлээс 775.3 мянган төгрөгөөр буурсан нь сумын бараа үйлчилгээний зардлын өглөг 775.3 мянган төгрөгөөр барагдсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Өр төлбөртэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо


Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,552,462.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 159,683.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	509,631.2	509,631.2	0.0
Өмч /төрийн/ ЛТӨҮГ/	509,631.2	509,631.2	0.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,772,654.3</b>	<b>1,932,337.6</b>	<b>159,683.3</b>
Өмнөх үеийн үр дүн	4,389,565.0	1,772,654.3	-2,616,910.7
Тайлант үеийн үр дүн	-2,616,910.7	159,683.3	2,776,594.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	110,494.1	110,494.1	0.0
<b>Дүн</b>	<b>2,392,779.6</b>	<b>2,552,462.9</b>	<b>159,683.3</b>

Эх сурвалж: Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 159,683.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагчид тус тусдаа төсвийн төслийг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох хэлтэст хүргүүлэн, нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 34 дүгээр тогтоолоор Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 1,422,943.2 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 1,141,113.9 мянган төгрөг байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр 408134.7 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 197,407.2 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал 281,829.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 227,372.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 308,200.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 93,569.8 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 98,885.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.


Сумын ИТХ-ын 2023 оны 07 сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тодотгож, 1,637,870.6 мянган төгрөг болсон байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 516,467.5 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 296,292.3 мянган төгрөгийн, улсын төсөвт байгууллагын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 281,829.3 мянган төгрөгийн Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 74,672.5 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 255,488.3 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 113,551.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 99,589.5 мянган төгрөг дутуу байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 1,000.0 мянган төгрөгөөр дутуу олгогдсон, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нь нөлөөлж байна.

д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	517,467.5	516,467.5	1,000.0
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	296,292.3	296,292.3	0.0
3	Улсын төсөвт байгууллагын тогтмол зардал	281,829.3	281,829.3	0.0
4	Татварын болон татварын бус орлого	294,101.5	255,488.3	38,613.2
5	Урьд оны үлдэгдэл	244,700.0	113,551.5	131,148.5
6	Үндсэн үйл ажиллагааны орлого	3,500.0	74,672.5	-71,172.5
ДҮН		1,637,890.6	1,538,301.1	99,589.5

Татварын болон татварын бус орлогоор 279,959.9 мянган төгрөгийг бүрдүүлж, татварын буцаан олголтод 24,471.6 мянган төгрөгийг, санхүүжилтэд 255,488.3 мянган төгрөгийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,449,689.0 мянган төгрөг буюу 88.5 хувьтай байгаа нь сумын ЗДТГ-ын цалинг хэт өндөр төлөвлөсөн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний



зардлыг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас төлөвлөсөн хэмжээнд зээл олгоогүй, сумын ИТХ, ЗДТГ, Ойн ангид санхүүжилт дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

**Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

*/мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	144,882.2	138,174.5	6,707.7	95.4 %
2	Засаг даргын Тамгын газар	666,064.3	639,874.4	26,189.9	96.1%
3	Орон нутгийн хөгжлийн сан	356,292.3	220,398.8	135,893.5	61.9%
4	Хоршоо хөгжүүлэх сан	132,000.0	120,829.0	11,171.0	-
5	Улсын төсөвт байгууллагын тогтмол зардал	281,829.3	276,951.3	4,878.0	98.3%
<b>ДҮН</b>		<b>1,637,890.6</b>	<b>1,449,689.0</b>	<b>188,201.6</b>	<b>88.5%</b>

*Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.*

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 32,468.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 32,465.6 мянган төгрөгийг тээвэр шатахуун, дотоод албан томилолт, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 2.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.*

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

**4. АУДИТЫН ТАЙЛАН**

**4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсвийн шууд захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.


Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Мөнхнасан гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түдэвтэй сумын Засаг дарга нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/38 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2,480,286.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 37,204.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу



27,903.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### 4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 3 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Түдэвтэй сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хяналт хэрэгжүүлээгүй, албан үүргээ хэрэгжүүлээгүйтэй холбоотой 154,376.7 мянган төгрөгийн зөрчилд сумын Засаг даргад сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд өгч, хэрэгжүүлж ажиллаагүй тул дараагийн шатны төсвийн захирагчид шилжүүллээ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	154,376.7	-	-	0%
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	1	154,376.7			0%

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 21,130.6 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 заалт зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 21,130.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 16,073.7 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

#### 5.2 Албан шаардлага өгөгдөөгүй



### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 21,130.6 мянган төгрөгийн зөрчил байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
Төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 21,130.6 мянган төгрөгийн зөрчил байна.	1	21,130.6					1	21,130.6				
Дүн	1	21,130.6					1	21,130.6				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал



/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

Б.МӨНХНАСАН

Огноо: 2024-03-25

